

ШҮҮМЖЛЭЛТ ЭРГЭЦҮҮЛЛЭЭР БАГШЛАХУЙГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

Т.Норовсүрэн, магистр, МУБИС

Abstract: Nowadays, many scholars have mentioned that there are no ready prescriptions to tell people whether their actions are right or wrong, so every teacher can work in productive and creative ways using his critical thinking skills. In order to think critically, those such as raise a hypothesis, ask a good question, and think creatively and logically.

Critical thinking, also called critical analysis, is clear, rational thinking involving critique. Its details vary amongst those who define it. During the process of critical thinking, ideas should be reasoned and well thought out/judged for the professional development.

The study aims at analyzing the current situation of how to use a holistic approach to critical thinking effectively in pre-service teacher training system and identifying the possibilities of how to support creative teachers to use this skill in their spontaneous teaching.

Teachers spoke of the importance of developing training strategies for thinking and critical success. For example: see the test questions and record-keeping skills and challenges, it is important to use judgment methods, including theoretical explanations. And it is important to see students reading magazine articles to implement critical thinking training, strengthened and promoted through observation notes, interviews, discussions protect inherent logic of his position and support the ability to refute. Reflections are in need of making specific analysis, discussion and criticism. A review of the impact on students is not unique value to give an idea of the main critical issues and increase expertise.

Түлхүүр үг: Шүүмжлэлт сэтгэлгээ, тогтсон хэв загвар, эргэцүүлэл

Удиртгал

Орчин үед эрдэмтдийн тэмдэглэснээр ийм асуудлыг ингэж шийднэ гэсэн бэлэн жорыг хэн ч хэлж өгөхгүй учраас багш бүхэн өөрийн ажлын талаар бүтээлчээр сэтгэн ажиллах хэрэгтэй. Аливаа асуудалд шүүмжлэлт эргэцүүллийн үүднээс таамаглал дэвшүүлэх, асуулт зөв тавих, бүтээлчээр логиктой хандаж, багш бэлтгэх болон мэргэжлийн хөгжлийг ахиулахад өөрийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тогтсон хэв маягаас салахад эргэцүүлэл чухал нөлөөтэй билээ. Багш бүхэн шүүмжлэлт эргэцүүллийн ур чадварыг, үр дүнтэй хэрэгсэл болгон ашиглах чухал байна. Иймээс багш өөрийн үйл ажиллагаанд шүүмжлэлт эргэцүүллийг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлж буй өнөөгийн байдлыг тодорхойлж, цаашид хэрхэн сайжруулах, эргэцүүлэгч багшийг бэлтгэх багш болон оюутан-багш үйл ажиллагаандаа хэвшүүлэхэд ямар арга зүйг баримтлан хэрэгжүүлэх асуудлыг тодорхойлох нь чухал болно.

Энэхүү судалгааны өгүүлэлд шүүмжлэлт эргэцүүлээр багшлахуйг дэмжиж буй өнөөгийн байдал, түүнийг хэрхэн сайжруулах боломжийг судлах зорилго дэвшүүлээ. Түүнчлэн шүүмжлэлт эргэцүүллийн талаар онол арга

зүйн ойлголтыг судлах, оюутан-багшийн шүүмжлэлт эргэцүүллийн өнөөгийн байдлыг судалсаны үндсэн дээр, шүүмжлэлт эргэцүүллийг багшлахуйд ашиглах боломжийг тодорхойлов.

Эргэцүүлэл, түүний мөн чанар

Сэтгэлгээний арга барилд суралцах үндсэн арга хэрэгсэл нь эргэцүүлэл юм. Эргэцүүлэл нь тухайн нөхцөл байдлыг асуултаар шинжих сэтгэлгээний арга барил билээ. Эргэцүүлэхдээ нотолгоо баримтад тулгуурлан асуултаа оновчтой боловсруулж иж бүрэн цогц байдлаар хийнэ. АНУ-ын эрдэмтэн Ж.Дьюи сурган хүмүүжүүлэх практикийн хоёр арга байдаг гэж үзсэн. Үүнд:

А Тогтсон хэв загвар. Зан заншил, ёсзүй, хууль дүрэм журам, стандартын дагуу ажиллан, онолыг практикт туршин хэрэгжүүлдэг, аливаад хандахдаа ийм байх ёстой гэж үздэг. Эргэцүүлсэн хэв загвар. Учир холбогдлыг нь тайлж бүтээлчээр хандах буюу аливаа асуудалд Яагаад? гэсэн байр сууринаас хандан шинжилдэг. Практик үйл ажиллагаанаас онол гардаг.

Энэ хоёр загвар нь өөр өөр байр сууринаас асуудалд ханддаг байна. Өнөөгийн хөгжлийн чиглэл бүтээлч эргэцүүллийн загвар руу хандаж

эргэцүүлэл нь мэргэжлийн хөгжлийн арга хэрэгсэл болжээ. Учир нь эргэцүүлэхийн зорилго нь тогтсон үйл хандлагаас шилжихийг нь дэмждэг. Мэдлэг бүтээгддэг учраас төгс байх аргагүй аливаа юмс, үзэгдэл, зүйлсийг заавал эргэцүүлэн тунгааж Яагаад? гэсэн байр сууринаас ханддаг.

Эргэцүүлэл нь энгийн жижиг зүйлд, мөн өргөн цар хүрээний цаг хугацаа шаардсан асуудалд ч шаардагдана. Эргэцүүлэл нь аливаа үзэгдэл, үйл явдал, зүйлсийн тухай асуултаар шинжих сэтгэхүйн үйл ажиллагаа мөн. Иймээс ач холбогдолыг нь бууруулж, хэтрүүлж болохгүй бөгөөд маш нягт нямбай, нарийн түвэгтэй үйл ажиллагаа байдаг. Хэл шинжлэлийн доктор Ж.Гунаасүрэн эргэцүүллийн тухай:

Мэдлэг дээшлүүлэхэд мэрийлттэй бол сөөм өснө.

Мэргэжил нэгтнээсээ ямагт сурдаг бол төө өснө.

Эрхэлсэн ажлаараа үлгэрлэдэг бол тохой өснө.

Эргэцүүлэн шүүж өөрийгөө ялдаг бол алд өснө гэж бичсэн.

Дээрхээс үзвэл эргэцүүлэл нь нөхцөл байдлыг асуултаар шинжих үйл ажиллагаа төдийгүй сэтгэлгээний арга барилд сургах бүтээлч хэрэглүүр юм (Байгалмаа, 2015, х.18-20).

Эргэцүүллийн талаарх эрдэмтдийн үзэл баримтлал

Эргэцүүлэн багшлахуйн тодорхойлолт нь эргэцүүлэх үйл ажиллагааны мөн чанартай уялдахаас гадна багш эргэцүүлэл хийх ёстой гэсэн агуулгыг илэрхийлж байдаг. Жишээ нь, Шоны (Schon, 1983) үйлдээ эргэцүүлэл хийх ойлголт нь мэргэшсэн хүмүүс мэргэжлийнхээ орчин нөхцөл, асуудлыг авч үзэх эсвэл тоймлон томъёолох замаар ялган таних, шийдэх арга замд хамаарч, мэргэжлийн үйл ажиллагаанд буй асуудлыг олох, шийдэх арга процессыг илэрхийлдэг.

Эргэцүүлэгч багш нар өөрсдийн багшлах үйл явц, түүний чанарын талаар эргэцүүлэн үнэлэх үйлийг тогтмол хийж болно. Гэхдээ үнэлгээг үргэлж өөрсдөө хийдэггүй нь тодорхой. Хамтарсан хийгээд эвсэг шүүмжийн хүрээнд Кампбелл, Кирыкидс, Мьюжс, Робинсон нар үе тэнгийнхэн хоорондоо хэлэлцэж, биесээ сонсож, асууж, багшлахуйн талаарх итгэл үнэмшил, санал бодлоо солилцож, харилцан дэмжих боломжтой гэжээ.

Дьюй /Dewey, 1933/ энгийн хийгээд эргэцүүлэх үйлүүдийн хоорондох зааг ялгааг дурджээ. Тэрбээр эргэцүүлэх үйлийг “идэвх, болгоомж, туйлбартайгаар аливаа итгэл үнэмшил, мэдлэгийн

баримжаалж буй хэлбэрийг ул үндэс, гарах үр дагавартай нь хамт авч үзэх” хэмээн тодорхойлсон. Тэр цагаас хойш эргэцүүллийн тухай багш нарын бодол санаанд эргэлт гаргасан Шоны “Эргэцүүлэгч багш” (The Reflective Practitioner, 1983), “Эргэцүүлэгч багшийг бэлтгэх” (Educating the Reflective Practitioner, 1987) гэсэн хоёр ном эргэцүүллийн асуудлыг улам баяжуулж өгсөн юм. Шоны “Эргэцүүлэгч багш” номонд практикийн шинэ танин мэдэхүйн асуудал туссан бөгөөд хүн аливаа зүйлийг хийх явцдаа хийж буй үйлээ эргэцүүлэх чадвараараа мэргэжлийн ахиц, чадамж, ур дүй бүрдүүлдэг тухай өгүүлжээ. Харин тэрхүү хандлагыг хэрхэн түгээх тухай асуудалд хоёр дахь номоо хэвлэгдэх хүртэл хариулт өгөөгүй юм. Багш, суралцагч нарын хэлэлцүүлэг, эргэцүүлэх үйлээр практикийг шинээр таних нөхцөл бүрдэнэ хэмээн тэрбээр нотолдог. Шоны бүтээлд хэд хэдэн судалгаа орсон байдаг. Харин багш болохоор суралцаж буй оюутнуудтай ажилладаг Макиннон багшлах дадлагын үеийн ажиглалтаар Шоны үйлээ эргэцүүлэх багшийн шалгуурыг боловсруулжээ (Donald A. Schon 1983).

Багшийн бодох, эргэцүүллийн тухай судалгааны хоёр дахь бүтээлийг судлаачид гаргасан байна. Эриксон, Пиаже, Кинг, Китченер нарын онолчид хүүхэд, залуус, насанд хүрэгчид өөрийн туршлагаас мэдлэг бүтээх үед үүсдэг танин мэдэхүй болон сэтгэл хөдлөлийн процессуудыг тодорхойлж гаргажээ. Энэ хандлагын талаарх ихэнх судалгаа нь хүн мэргэжлийн болоод бие хүний чадамжтай байх дотоод хэрэгцээг шаарддаг тухай, түүнчлэн таатай орчин нөхцөлд эерэг харилцан нөлөөлөл байсан нөхцөлд бол хүний чадамж тодорхой үе шатуудыг дамжин сайжирдаг тухай ерөнхий үр дүнг дахин дахин баталгаажуулдаг байна. Түүнчлэн эдгээр судалгаа нь багш нарын чадавх, бэлтгэл эргэцүүлэх үйл хийх идэвхээрээ ялгаатайг харуулдаг. Тухайлбал, тун нухацтай түвшинд тухайн багш өөрийн арга барилыг эргэн сайжруулахад тус болно гэж үзсэн байдаг (Берт Криймерс ба бусад, 2014, х. 29-41).

Судалгааны арга зүй. Судалгааг холистик чиг хандлагаар явуулж, чанарын дүн шинжлгээний аргуудыг түлхүү хэрэглэлээ. Шүүмжлэлт эргэцүүллийн арга зүйг ашиглан багшлахуйг сайжруулан дэмжиж буй өнөөгийн байдлыг тодорхойлж, сургалтад хэрхэн нөлөөлж буй нөхцөл байдлыг ажиглан тодорхой шинжилгээ хийх, нэвтрүүлэх боломжийг дараах үе шаттай судалж үзсэн болно. Үүнд:

- I Шүүмжлэлт эргэцүүллийн өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор судалгааны ажилд эргэцүүлэл хийх даалгаварын үр дүнд шинжилгээ хийв. “Эргэцүүлэл хийсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нь МУБИС “Лавай” Эрдэм шинжилгээний бичиг” сэтгүүл №10,11 МУБИС-иас эрхлэн хэвлэсэн “Монгол туургатан хүүхэд” 2014 хурлын эмхэтгэл гэх мэт/
- II Багшлахуйн практик шүүмжлэлт эргэцүүллийг хэрэгжүүлж байгаа байдал түүний чанар үр дүнг тодорхойлох зорилгоор II дамжааны оюутнуудын дунд эссэ бичлэг, өгүүлэлд шинжилгээ хийн эргэцүүлэл бичих даалгаварт анализ хийв.
- III Шүүмжлэлт эргэцүүллийн багшлахуйд ямар байр суурьтай байгааг илрүүлэх Асуулгын аргаар /эрэмбэлэх, үзэл бодлыг тодорхойлох асуулга/ тодорхойлж дүгнэлт хийх.

Оюутны бүтээлд дүн шинжилгээ хийсэн байдал

/Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэл сонгон авч эргэцүүлэл хийсэн байдал/

Оюутны "Монгол туургатан хүүхэд" эрдэм шинжилгээний хурлын илтгэлээс нэг эрдэмтний илтгэлийг сонгон авч түүнд шинжилгээ хийсэн бөгөөд нийт 34 оюутан өөр өөр судлаачдын илтгэлд эргэцүүлэл хийснээс 28 оюутан буюу 82.3% бүрэн уншаагүй бөгөөд шалгах асуулт, өөрийн ойлголтыг илэрхийлэх чадвар сул, 6 оюутан буюу 17.6% нь протокол хөтлөл, бэрхшээлийг олж харсан байдал, эрдэмтдийн судалгааны ажлын гол санааг тодорхойлоход чиглэсэн эргэцүүллийг хийсэн байлаа. Дээрх байдлаас үзэхэд шүүмжлэлт эргэцүүлэл хийх чадвар сул байгаа нь харагдаж

байна. Иймээс өөрийн байр суурийг логиктой хамгаалах, тэмдэглэл хөтлөх чадвар нь /тусгай зөвлөгөө болж чадна/, бэрхшээлийг олж харах зэрэг үйл ажиллагааг шүүмжлэлт эргэцүүлэлээр дэмжих нь чухал байгааг харуулж байна. Эргэцүүллийг нотолгоо баримтад тулгуурлан асуултаа оновчтой боловсруулж иж бүрэн цогц байдлаар хийх нь чухал байна. Багш, сурган хүмүүжүүлэгчдийг эргэцүүллийн санааг тодруулах, өгүүлэх, өгүүлэл бичих, эргэн тунгаах, үйлээ судлах, судалгаанаас үйл ажиллагаа руу шилжих зэрэгт улам чадваржуулах, шаардлагатай байна.

Эссэ бичлэгт дүн шинжилгээ хийсэн байдал


Эссэ бичлэгийг МУБИС-ийн Архангайн Багшийн сургуулийн II дамжааны 57 хүүхэд “Хүүхдийн хөгжил төлөвшилд гарч буй өөрчлөлт” сэдвээр хийсэн бөгөөд оюутан тус бүрийн эссэ бичлэгт дүн шинжилгээ хийсэн болно.

Дүгнэлт: Тодорхой нөхцөл байдлын жишээ гаргасан байдал-5.2%, баримт нотолгоо мэдээлэл цуглуулах-19.2%, эрдэмтдийн үзэл онолыг тусгасан байдал-73.6%, өөрийн байр сууринаас дүгнэх чадвар, практик үйл ажиллагаа таньж олсон чадвар-1.7%. Дээрх судалгаанаас үзэхэд оюутан өөрийгөө таних, сорих чадварт суралцах багшлахуйн үнэт зүйл болон онолыг задлан шинжлэх зэрэг чадварт суралцаж байна. Эргэцүүлэлдээ өгөх үнэлгээг үргэлж өөрсдөө хийдэггүй нь тодорхой. Иймээс эссэ бичлэгийн дараа оюутан эссэ бичлэгээ тайлбарлаж танилцуулах, мөн багшийн зүгээс тусгайлан зөвлөгөө өгөх, засах боломж олгох, хамтарсан хийгээд эвсэг шүүмжийн хүрээнд үе тэнгийнхэн хоорондоо хэлэлцэж, биесээ сонсож, асууж, багшлахуйн талаарх итгэл үнэмшил, санааг оноог солилцож, харилцан дэмжих боломжтой.

Багшаас авсан асуулгын үр дүн

Диаграмм 1

1. Багш сурган хүмүүжүүлэх практикийн доорх арга барилын алийг нь хэрэгжүүлдэг вэ?



А. Тогтсон хэв загвар Б. Эргэцүүлсэн хэв загвар

Дүгнэлт: Энэ хоёр загвар нь өөр өөр байр сууринаас асуудалд ханддаг судалгаанаас үзэхэд тогтсон хэв загвар - 82.6%, Эргэцүүлсэн хэв загвар - 17.4% өнөөгийн хөгжлийн чиглэл бүтээлч эргэцүүллийн загвар луу хандаж эргэцүүлэл нь мэргэжлийн хөгжлийн арга хэрэгсэл болж байна. /График №1/ Иймээс оюутан практик үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг онолын түвшин тайлбарлах чадварыг дэмжих нь чухал байгааг харуулж байна.

2. Оюутны бүтээлч эргэцүүллийн түвшинг тодорхойлно уу?

- А.Бодит байдлыг шууд үнэлэх
- б. Нөхцөл байдал
- в. Шүүмжлэлтэй эргэцүүлэх

Дүгнэлт: Бодит байдлыг шууд үнэлж зорилгодоо хүрэх боломжийн эргэцүүлэл 52.6% байв. Ямарваа нэгэн үйлийн ёсзүйн нөлөөллийг тооцож үздэггүй, асуудал дэвшүүлдэггүй. Нөхцөл байдлын эргэцүүлэл 32.5%. Энэ нь сургах үйлийг

нөхцөл байдалд задлан шинжлэх буюу яагаад миний практик үйл ажиллагаа ийм байгаа талаар эргэцүүлэх явдал болно. Тодруулбал, тухайн суралцагч нөхцөл байдалд ямар бэрхшээлтэй тулгарч байна вэ? Үүнийг шийдвэрлэх ямар арга замыг сонгож хэрэгжүүлж байна? Өөр илүү үр дүнтэй ямар арга стратеги байж болох вэ? зэрэг асуулт тавьж эргэцүүлнэ гэсэн үг юм. Шүүмжлэл буюу 3-р түвшний эргэцүүлэл 5.7% байгаа нь сурах/ сургах үйл ажиллагааг онол аргагүй, концепци, нийгмийн хэм хэмжээ, шудрага ёс, хүний эрх, эрхзүйн талаас нягталж шинжихийг хэлнэ. Энэ түвшинд бид хүүхдүүдээ хэрхэн сургавал зохилтой вэ? Тэдгээрийн хэрэгцээ шаардлагыг яаж хангах ёстой вэ? гэсэн асуултуудыг тавин шийдвэрлэх чадвартай болно. Иймээс багшлахуйд 3-р түвшний буюу шүүмжлэлт эргэцүүллийг дэмжиж ажиллах нь чухал байна.

3. Эргэцүүллийг сайжруулахад чиглэсэн заах аргын ямар стратегиудыг голлон ашиглаж байна вэ?

- а. Үйлийн судалгаа б.бичлэг в. Этнограф буюу угсаатан судлал г. Хөтөлбөрийн шинжилгээ д.Хөтөлбөр боловсруулах

Диаграмм 2



Дүгнэлт: Үйлийн судалгаа-45.3%, Хөтөлбөр боловсруулах-25.6%, видео бичлэг-35.8% зэргийг оюутныг эргэцүүлэх чадварыг сайжруулахад ашиглаж байна. Практикт эдгээр хандлагууд

нь ихэвчлэн өгүүлэл унших, багатган харах, ажиглалтын тэмдэглэл хөтлөх, ярилцах, үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг үйлүүдээр дамжин хэрэгжиж байна.

ДҮГНЭЛТ

Багш оюутны үйл ажиллагаанд хийсэн судалгаанаас үзэхэд шүүмжлэлт эргэцүүлээр багшлахуйг дэмжин ажиллахад арга зүйн үүднээс дараах асуудал чухал болохыг дүгнэж байна.

- Оюутнуудын эрдэм шинжилгээний өгүүлэлд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд

эргэцүүлэх чадвар сул байгаа нь харагдаж байна. Энэхүү байдал нь багш нараас авсан асуулгын үр дүнтэй зөрчилдөж байна. Тухайлбал, багшлахуйг сайжруулахад чиглэсэн заах аргын стратегиуд нь голлон эргэцүүллийг сайжруулахад чиглэсэн

байна. Иймд багш заах аргад ашиглаж буй арга барилаа дахин харах, үр нөлөөг нь сайжруулах, мөн оюутанд өөрийн байр суурийг логиктой хамгаалах боломж гаргах, тунгааж эргэцүүлэх нөхцлийг бий болгох, аливаад ерөнхий дүгнэлт өгөх чадварыг дэмжин ажиллах нь чухал байна.

- Оюутны эссэ бичлэгт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд амьдралын тодорхой жишээ гаргах, нотолгоо цуглуулах чадвар, практик үйл ажиллагаанд гарч буй бэрхшээлийг таньж дүгнэх чадвар сул байгаа нь харагдаж байна. Иймээс маргааны хэв шинжтэй сургалтын арга зүйг ашиглах. Тодруулбал, бусдын үзэл бодлыг шүүмжилж няцаах, өөрийн санааг батлах, зөв дүгнэлт өгөх чадварыг дэмжин ажиллах.
- Багш нарын судалгаанаас харахад сурган хүмүүжүүлэх арга барил нь хэвшмэл сэтгэлгээнд баригдаж байгаа нь харагдаж байна. Иймээс багшлахуйг сайжруулахад практик үйл ажиллагаанд гардаг бэрхшээлийг сонгон авч онолоор батлах, эргэцүүлэн тунгаах, Яагаад? гэсэн байр сууринаас хандах чадварыг дэмжих нь зүйтэй болно. Ингэснээр багшийн сэтгэлгээ шинэчлэгдэж, оюутанд зөв үзэл төлөвших, саад бэрхшээлээ олж харах, нөхцөл бий болно.
- Эргэцүүллийн үйл ажиллагаанд тодорхой анализ хийх, хэлэлцүүлэх, шүүмж хийх чадварыг оюутан эзэмших нь чухал. Энэ үйл явцад багшийн зүгээс логик учир шалтгааны асуулт тавих нь чухал бөгөөд ирээдүйн багш нарын сургалтын үйл ажиллагаанд гарах саад бэрхшээлийг таамаглан илрүүлэх ач холбогдолтой билээ.
- Оюутны дотоод мэдрэмжийг хөгжүүлэх, өдөөх, сурах, эргэцүүлэл хийх сонирхлыг мэдрүүлэх.
- Шүүмжлэлт эргэцүүллийг сургалтад хэрэгжүүлэхэд оюутан өгүүлэл унших, бататган харах, ажиглалтын тэмдэглэл хөтлөх, ярилцлага, хэлэлцүүлэг хийх зэрэг заах аргын стратегиудыг ашиглах нь чухал болохыг судалгааны үр дүн харуулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Donald A. Schon (1983). The reflective practitioner: *How professionals think in action*
- Andrew Pollard (2008). *Reflective Teaching*.
- Forde et al, (2006). Literature Review on Teacher Education in the 21st Century. www.scotland.gov.uk
- References About Baker El-Dib, M. (2007). Levels of reflection in action research. An overview and an assessment tool. *Teaching and Teacher Education*, 23(1), 24-35.
- Берт Криймерс, Леонидас Кириакайдс, Панаиотис Антонио *Багшлахуйн чанарыг сайжруулахад багшийн хөгжил.*, Springer 29-41 хуу.,
- Байгалмаа.Ч.,(2015) Боловсролын судалгааны арга зүй.,УБ
- Brown, J. S., Collins, A., & Duguid, P. (1989). Situated cognition and the culture of learning. *Educational Researcher*, 18(1), 32-42.
- Dewey, J. (1933). *How we think*. Buffalo, NY: Prometheus Books.
- Husu, J., Toom, A., & Patrikainen, S. (2008). Guided reflection as a means to demonstrate and develop student teachers' reflective competencies. *Reflective Practice: International and Multidisciplinary Perspectives*, 9(1), 37-51.